



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/630

Номгон

Өлзийт сумын дулаан үйлдвэрлэлд Залаа цагаан хоршооноос оруулсан хөрөнгийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн 101 тогтоолын 2 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өлзийт сумын дулаан үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтанд Залаа цагаан хоршооноос оруулсан хөрөнгийн бодит болон зах зээлийн үнэлгээг тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Идэрмөнх (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Ш.Гэрэлсүх (Санхүү, төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн)


Б.Жамъяндорж (Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн)

Г.Баатартогтох (Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

Э.Долгорсүрэн (Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)

2. Дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдон Залаа цагаан хоршооноос гаргасан хөрөнгийн бодит болон зах зээлийн үнийг судалж дүнг 2021 оны 11 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Идэрмөнх)-д үүрэг болгосугай.

3. Захирамжын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгальмаа)-д даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХСАЙХАН

601210471